


2011

Дэлхийн сайн дурын
үйл ажиллагааны
төлөв байдал

Дэлхий нийтийн сайн сайхны
төлөө эрхэмлэх зүйлс

ТАЙЛАН



UN
Volunteers

inspiration in action



UN
Volunteers

inspiration in action

НҮБ-ын Сайн дурын үйл ажиллагааны хөтөлбөр нь дэлхий дахинд сайн дурын үйлсээр дамжуулан энх тайван, хөгжил дэвшилд хувь нэмэр оруулдаг НҮБ-ын байгууллага юм.

Сайн дурын үйл ажиллагаа нь хөгжил дэвшилд тулгарч байгаа сорилт, бэрхшээлүүдийг шийдвэрлэх хүчирхэг хэрэгсэл болохын сацуу хөгжил дэвшлийн хурд, хэв шинжийг өөрчлөхөд тусалдаг.

Сайн дурын үйлс нь иргэд хувь хүмүүсийн эв нэгдэл, итгэлцэл, харилцан ойлголцолыг бэхжүүлж, тэдний оролцоог нэмэгдүүлэх боломжийг бий болгосноор сайн дурынхан, цаашлаад нийгэмд чухал үүрэгтэй, ашиг тусаа өгдөг үйл ажиллагаа юм.

НҮБ-ын Сайн дурын байгууллага нь сайн дурын үйл ажиллагааг сурталчлан таниулахад тусалж дэмжихийн зэрэгцээ, хөгжлийн хөтөлбөрт уг үйл ажиллагааны оролцоог хангаж, тусгахын тулд бусад байгууллагатай хамтран ажиллаж, НҮБ-ын болон дэлхийн олон улс орны сайн дурын үйл ажиллагааг нэгтгэх замаар хөгжил дэвшил, энх тайвны үйлсэд хувь нэмрээ оруулдаг.

НҮБ-ын Сайн дурын байгууллага нь сайн дурын үйлсийг түгээмэл, олон нийтийг хамарсан төдийгүй, чөлөөт сонголт, чин хүсэл эрмэлзэл, хүчин чармайлт, эв нэгдэл зэрэг эрхэмлэх зүйлээрээ ялгаатай олон хэлбэр бүхий үйл ажиллагаа хэмээн үздэг.

НҮБ-ЫН САЙН ДУРЫН БАЙГУУЛЛАГЫН ХОЛБОО БАРИХ МЭДЭЭЛЭЛ:

НҮБ-ын Сайн дурын байгууллагын тухай ерөнхий мэдээллийг дараах хаягаар холбогдож авна уу:

United Nations Volunteers (UNV)

Шуудан: 260 111

D-53153 Бонн

Герман Улс

Утас: (+49 228) 815 2000

Факс: (+49 228) 815 2001

Интернет: www.unvolunteers.org

Facebook хуудас: www.facebook.com/unvolunteers

YouTube сувар: www.youtube.com/unv

UNV Office in New York

Нью Йорк дахь НҮБ-ын Сайн дурын байгууллагын оффис

НҮБ –ын цамхаг - 2

Нью Йорк, NY 10017, АНУ.

Утас: (+1 212) 906 3639

Факс: (+1 212) 906 3659

Электрон шуудан: RONA@unvolunteers.org

НҮБ-ын Сайн дурын ажилтан болох талаарх мэдээллийг тус байгууллагын сайтаас авна уу: www.unvolunteers.org
www.onlinevolunteering.org (онлайн).



Нэгдсэн Үндэсний Байгууллагын
Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ)

Produced on 100% recycled FSC paper with vegetable-based inks.
The printed matter is recyclable.



2011

Дэлхийн сайн дурын
үйл ажиллагааны
төлөв байдал

Дэлхий нийтийн сайн сайхны
төлөө эрхэмлэх зүйлс

ТАЙЛАН

© НҮБ Сайн дурын байгууллага, 2011
Хэвлэсэн: НҮБ-ын Сайн дурын байгууллага
Орчуулгыг: Прайм Продакшин, Их Британи
Дизайныг: “Бэйлайн Артс”, Их Британи
Шаб Чакраборты (хавтасны загвар)
Дани Улс, “Феникс Дизайн Эйд”-н хэвлэв.

Энэхүү тайлангийн тойм хувилбарыг араб, хятад,
англи, франц, орос, испани хэл дээр хөрвүүлсэн
эхийг www.unvolunteers.org/swvr2011 сайтаас
авч болно.

Энэхүү материалын аль нэг хэсгийг хуулбарлахад
зохих зөвшөөрөл авах шаардлагатай.

ISBN: 978-92-95045-43-9

Дэлхийн сайн дурын үйл ажиллагааны төлөв байдал Тайлангийн баг

Ахлах зохиогч

Роберт Лэй

Судалгаа болон боловсруулалтын баг

Дэвид Хортон Смит (Ахлах судлаач),
Корнелиа Жиезинг, Мариа Жозе
Леон, Дебби Хаски- Левентал,
Бенжамин Ж. Лоу, Жакоб Мувати
Мати, Сабин Страсбург

Редактор

Пол Хокенос

Төслийн менежер

Эйжен Эйтак

Мэдээлэл харилцааны мэргэжилтэн

Лотар Микулла

Захиргааны дэмжих баг

Вера Чробок, Жоаннес Булманн

Энэхүү тайланд тусгагдсан дүн шинжилгээ, бодлогын зөвлөмжүүд нь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн байр суурийг шууд тусгаагүй болохыг анхаарна уу. Тайлангийн судалгаа болон боловсруулах ажлыг Дэлхийн сайн дурын ажиллагааны төлөв байдлын Тайлангийн баг болон НҮБ-ын Сайн дурын байгууллагын Гүйцэтгэх Зохицуулагч Флавиа Панзиери тэргүүтэй зөвлөхүүдийн баг хамтран гүйцэтгэв.

Тайланд зарим бараа бүтээгдэхүүний худалдааны нэр, арилжааны үйл ажиллагааны тухай дурдсан нь сурталчилгааны ямар нэг зорилго агуулаагүй болно.

Өмнөх үг

Сайн дурын үйл ажиллагаа нь ямар ч нийгмийн үед тохиолддог хэвшмэл үзэгдэл юм. Энэхүү үйл хэргийг тодорхойлох нэр томъёо, түүнийг илэрхийлэх хэлбэр нь дэлхийн улс орнууд, янз бүрийн хэлэнд өөр боловч ямар нэгэн шан харамж авах зорилгогүйгээр, сайн дураар, эвлэлдэн нэгдэж, нийтийн үйл хэрэгт хувь нэмрээ оруулах чин хүсэл эрмэлзлэл, энэ бүхнийг хөдөлгөгч үнэт зүйл болох нь нийтлэг түгээмэл билээ.

Сайн дурынхан НҮБ-ын Дүрэмд заагдсан шударга ёс, тэгш эрх, эрх чөлөө зэрэг үнэт зүйлийг эрхэм зорилго болгон ажилладаг. Сайн дурын үйл ажиллагааны янз бүрийн хэлбэрийг бүх талаар хөхиүлэн дэмжиж байгаа бол тухайн нийгмийн байгуулал нь иргэнийхээ сайн сайхны төлөө үйлчилдэг юм байна гэж ойлгож болно. Харин нийгмийн зүгээс сайн дурынхны хувь нэмрийг ойлгож дэмжлэг үзүүлдэггүй бол иргэдийнхээ нийгмийн сайн сайхны төлөө үйлчлэх нэг чухал боломжийг алдаж байна гэсэн үг.

Арван жилийн өмнө Олон Улсын Сайн Дурынхны жилийг зарласнаар ард түмнүүдийн нэгдэл нягтрал, хамтын үйлс хэрэг, хөгжил цэцэглэлтэнд сайн дурынхны оруулж байгаа хувь нэмрийг дэлхий дахинд ойлгож үнэлэхэд түлхэц болсон. 2015 он гэхэд Мянганы Хөгжлийн Зорилтуудад хүрэхийн төлөө хөгжил дэвшлийг эрчимжүүлэхээр чармайж байгаа энэ цаг үед хөгжлийн аливаа төлөвлөгөө, стратегид сайн дурын үйл ажиллагааны оролцооны тэр бүр талаар тодорхой зүйл тусгаагүй, хөгжил дэвшлийн тухай яриа хэлэлцүүлгийн үед хааяа нэг цухас дурдагдсан төдий үлдэж байна.

НҮБ-ын Сайн дурын хөтөлбөрөөс анх удаа Олон улсын сайн дурын үйл ажиллагааны 10 жилийг тэмдэглэхтэй холбогдуулан Сайн дурын үйл ажиллагааны тайлан гаргахаар санаачилсан юм. Тайланд сайн дурын үйл ажиллагааны талаарх олон нийт тэр бүр анзаардаггүй хүч бололцоог онцлохын сацуу орчин цагийн хөгжлийн загварт сайн дурынхны хувь нэмрийг тусгадаггүй учраас бүрэн төгс бус болохыг нотлон харуулсан.

Сүүлийн хорин жилийн хугацаанд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр хүний эрх чөлөө, сонголтыг өргөжүүлж, урт удаан эрүүл аж төрөх, боловсрол эзэмших, сайн сайхан амьдрах боломжийг нэмэгдүүлэх зорилготой хүний хөгжлийн үзэл баримтлалыг дэвшүүлэн ажиллаж байна.

Хүний Хөгжлийн тайланд дурдсанаар хөгжлийн үр өгөөжийг зөвхөн нэг хүнд ноогдох Үндэсний нийт бүтээгдэхүүний (ҮНБ) хэмжээгээр бус иргэдийн сонголт өсөн нэмэгдэж, тэдний амьдралын чанар хэрхэн сайжирсанаар хэмжиж дүгнэж байх нь зүйтэй юм.

Хүний хөгжлийн үзэл баримтлалын анхаарлын төвд хүн байдаг. НҮБ-ын Сайн дурын үйл ажиллагааны тайланд уг асуудлыг хөндсөн бөгөөд хүний болон нийгмийн сайн сайханд материаллаг бус хувь нэмрийн ач холбогдлыг онцолсон байна. Материаллаг байдал - эрүүл мэнд, боловсрол, боломжийн ажил нэн чухал хэвээр байх бөгөөд иргэдийн оролцоо, эрх мэдлийг нэмэгдүүлэх, чадавхижуулах, тэдний идэвх дээшлэхийн хэрээр сайн дурын үйл ажиллагаа идэвхжинэ.

Дэлхийн Хүний хөгжлийн тайлан-2010-д “Аливаа хөгжлийн анхаарлын төвд хүнийг чухалчилснаар өргөн хүрээг хамарсан, эрх тэгш ижил үйлчлэх хөгжил дэвшилд хүрэх, иргэдийг өөрчлөлт хөгжилд идэвхтэй оролцох боломж олгодог”. НҮБ-ын Сайн дурын үйл ажиллагааны тайланд ямар ч нийгмийн үед сайн дурын үйл ажиллагаа хүний чадавхийг төлөвшүүлэх хамгийн үр дүнтэй арга зам болохыг нотолж байгаа.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд өөрчлөлт шинэчлэлийн үйл явцыг өрнүүлэх бодлого, чадамж, байгууллага институцийг төлөвшүүлэхэд улс орнуудад дэмжлэг үзүүлэх нь зүйтэй гэж үздэг.

Үр өгөөжтэй байдлыг хангахын тулд аливаа бодлогын өөрчлөлт шинэчлэлийг бүр анхан шатнаас эхлэх хэрэгтэй. Хамтын нийгмийн түвшинд боловсруулсан стратеги энэхүү зорилгыг биелүүлэхэд тусална.

Энэхүү тайлан нь сайн дурын үйл ажиллагаа хөгжил дэвшил, энх тайвны үйлсэд оруулж байгаа хувь нэмрийн талаарх ойлголтыг сайжруулж, энэ талаарх хэлэлцүүлгийг өрнүүлэх ажилд түлхэц болох юм.

Хелен Кларк

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Захирагч

Удиртгал

Энэхүү тайландэлхийн ард түмнүүдийг бусдын сайн сайхны төлөө үйлчлэхэд зоригжуулагч түгээмэл эрхэмлэх зүйлс, нийгэм болон хувь хүнд сайн дурын үйлс ямар нөлөө үзүүлж байгаад гол анхаарлаа хандуулсан. Нийгэм болоод хувь хүний сайн сайхны төлөөх үйлсэд хувь нэмрээ оруулах, хамтын ажиллагааг дэмжих, оролцоог өрнүүлэхэд сайн дурын үйл ажиллагаа чухал үүрэгтэй.

10 жилийн өмнө 2001 онд Олон улсын сайн дурынхны жилийн эцэст НҮБ-ын Ерөнхий Ассамблей дээр 126 гишүүн орон сайн дурын үйлс болхөгжлийн чухал хүчин зүйл юм гэдгийг хүлээн зөвшөөрч тогтоол гаргасан. Энэхүү тогтоол нь улс орнуудын засгийн газар, НҮБ-ын системийн байгууллагууд, төрийн болон төрийн бус бусад байгууллагууд сайн дурын үйлсийг дэмжих, түүнд туслалцаа үзүүлэх талаар бодлогын олон тооны зөвлөмжөөр хангасан юм.

Тэр цагаас хойш эдгээр зөвлөмжийн заримыг хэрэгжүүлэхэд тодорхой ахиц дэвшил гарч байна. Олон улсын сайн дурын үйл ажиллагааны 10 жилийн ойг тэмдэглэж байгаа энэ үед уг үйл ажиллагааны хувь нэмрийг өнөөг хүртэл зохих ёсоор үнэлэхгүй хэвээр байна. Сайн дурын ажиллагааг нийгмийн сайн сайхны төлөөх үйлс, иргэдийн оролцоог дэмжихэд чиглэсэн аливаа төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн үндсэн хэсэг бус харин дагалдах зүйл мэт авч үзэх асуудалд тооцсоор байна.

Энэхүү тайлан сайн дурын үйл ажиллагааг нийгэм, улс түмний тогтвортой хөгжил дэвшлийн үндсэн бүрэлдэхүүн хэсэг болохыг таниулах, хүлээн зөвшөөрүүлэхэд өөрсдийн зүгээс зохих хувь нэмрээ оруулна гэдэгт итгэлтэй байна. Хурдтай өөрчлөгдөж байгаа орчин үетэй харьцуулахад сайн дурын үйл ажиллагаа тогтмол оршиж байдаг зүйл. Түүнийг илэрхийлэх хэлбэр нь өөр өөр байж болох авч үзэл бодлоороо нэгдэх, нэгэн үйлсэд хамтран зүтгэх үндсэн үзэл санаа нь язгуур цөмдөө хөдлөшгүй, өөрчлөгдөшгүй дэлхий дахинд нийтлэг хэвээр байдаг. Сайн дурын ажиллагаа нь аль ч соёл, нийгэмд ижил тохиолдох, хүмүүнлэг үзлийн жинхэнэ илрэл юм.

Орчин цагт байнга хувирч байдаг үйлдвэрлэл, хэрэглээний мөн чанарыг өөрчлөх шаардлагатай болсныг бид улам бүр тодорхой ойлгож байгаа. Үүнд нэг талаас улс төрийн хүсэл эрмэлзэл шаардлагатай. Мөн үүний нэгэн адил иргэдийн идэвх

оролцоо, сэдлийг өрнүүлэх нь зүйтэй. Өнөөг үед дэлхий дахины бүх асуудлыг шийдвэрлэх цорын ганц арга зам нь сайн дурын үйлс гэж хэлэхгүй ч хөгжил дэвшлийн цорын ганц хэмжүүр нь зөвхөн эдийн засгийн ашиг орлого, хувь хүмүүсийн амин хувийн ашиг сонирхол бус, харин тэдний эрхэмлэх зүйл, итгэл үнэмшлийг мөн нэг үзүүлэлт болгож үзэх стратеги төлөвлөгөөний салшгүй бүрэлдэхүүн хэсэг нь байх ёстой.

Сайн дурынхны оролцоотойгоор хийгдсэн олон өөрчлөлт шинэчлэлтийн жишээг бид дараах бүлэгт танилцуулж байна. Үүгээрээ сайн дурын үйлс хүний хөгжилд яагаад ийнхүү чухал ач холбогдолтой болохыг харуулахыг зорьсон билээ. Хамгийн гол нь жинхэнэ хүмүүнлэг энэрэнгүй нийгэм нь сайн дурын үйл ажиллагааны эрхэмлэн баримтлах зүйлс болох итгэл үнэмшил, эв нэгдэл, болон харилцан итгэлцэлийг үйл ажиллагааныхаа гол чиг шугам, удирдлага болгох ёстой гэж бид үздэг.

НҮБ-ын Сайн дурын үйл ажиллагааны энэхүү тайланг бэлдэж байх явцад бид олон тооны тодорхойлолт болон арга зүйн асуудлыг авч үзэх шаардлагатай тулгарч байсан. Хүмүүнлэг ариун үйлсийн нэг болох энэхүү үйл хэргийн мөн чанар, цар хүрээний талаарх ойлголтыг гүнзгийрүүлж, цаашдын судалгаа шинжилгээ зайлшгүй шаардлагатай гэдгийг бид сайтар ойлгож байгаа. Энэхүү тайлан нь тодорхой хариулт өгөх бус харин өргөн далайцтай бүх нийтийг хамарсан хэлэлцүүлгийн эхлэлийг тавих юм.

Цаашид бид дэлхий дахинд сайн дурын үйл ажиллагааны санаачлага идэвх, цар хүрээ, түүний нөлөөний талаарх ойлголтоо улам бүр гүнзгийрүүлэхийг зорьж байна.



Флавиа Панзиери

*НҮБ-ын Сайн дурын байгууллагын
Гүйцэтгэх Зохицуулагч*

“Аливаа улс үндэстний жинхэнэ баялаг нь ард түмэн юм”

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Хүний Хөгжлийн Тайлан (1990)

Сайн дурын үйл ажиллагаа бол хүмүүсийн харилцааны үндсэн илэрхийлэл бөгөөд энэ нь хүмүүс амьдарч байгаа нийгмийнхээ үйл хэрэгт оролцож, өөрсдийгөө бусдад хэрэгтэйгээ мэдрэх тухай асуудал юм. Нийгмийн харилцааны салшгүй нэг хэв шинж болох сайн дурын үйлс нь хувь хүмүүс болоод нийгмийн сайн сайханд зайлшгүй чухал ач холбогдолтой гэдэгт бид итгэлтэй байна. Сайн дурын үйл ажиллагааны ёс зүйн дээд хэмжээ нь эв нэгдэл, харилцан ойлголцол, итгэлцэл, нийгэм, хамт олны гишүүн байх, эрх, боломжоор хангах зэрэг үнэт эрхэмлэх зүйлсийн хамт хүмүүсийн амьдралын чанарт чухал нөлөө үзүүлдэг.

Өнөөдөр дэлхий дахинд хүмүүс ядуурлыг бууруулах, эрүүл мэнд боловсролын үндсэн хэрэгцээг хангах, аюулгүй, эрүүл цэвэр усаар хангах, эрүүл ахуйн зохих нөхцлийг бүрдүүлэх, байгаль орчны асуудал болон цаг уурын өөрчлөлтийн асуудлыг шийдвэрлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, нийгмийн ялгаварлан гадуурхах болон хүчирхийлэл, зөрчил мөргөлдөөний эсрэг тэмцэх гэх мэт олон өөр өөр зорилгоор сайн дурын үйл ажиллагаанд нэгдэн орж байна.

Хүмүүс болон нийгмийн сайн сайхныг бий болгосноор сайн дурын үйл ажиллагаа энх тайван хөгжил дэвшилд зохих хувь нэмрээ оруулдаг. Сайн дурын үйл ажиллагаа нь үндэсний, олон улсын, төрийн бус байгууллага, иргэний нийгмийн болон нийгэм улс төрийн хөдөлгөөнүүдийн үндсэн тулгуур болохоос гадна, төрийн байгууллагын түвшинд болон сүүлийн үед хувийн секторт улам бүр түгээмэл үзэгдэл болсоор байна.

Сүүлийн үед, ялангуяа НҮБ-аас 2001 оныг Олон улсын сайн дурынхны жил болгон зарласнаас хойш сайн дурын үйл ажиллагааны талаарх ойлголт, хандлагад нааштай ахиц гарч байгаа боловч өнөөг хүртэл энэхүү үзэгдлийг зохих ёсоор үнэлэх, түүний хувь нэмрийн талаарх бүрэн гүйцэд ойлголт төлөвшөөгүй хэвээр байна.

Ихэнх тохиолдолд сайн дурын ажиллагааг энх тайван, хүний хөгжлийн асуудлаас салангид авч үздэг. Тэгвэл одоо нийгмийн амьдралын сайн сайханд сайн дурын ажиллагааны оруулах хувь нэмрийг бодитойгоор үнэлэх, хөгжил дэвшлийн загварын үндсийг бүрдүүлэгч салшгүй нэг хэсэг

боловч өнөө хэр орхигдуулсаар байгаа алдаа дутагдлаа залруулах шаардлагатай болоод байгааг ойлгох цаг ирээд байна.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Хүний Хөгжлийн анхны тайланд “Ард түмэн бол аливаа улсын жинхэнэ баялаг юм” гэж дурдсан байдаг. Хөгжил дэвшил нь хүмүүсийн хүссэнээрээ сайхан амьдрах сонголт боломжийг нэмэгдүүлдэг. Хүмүүсийн боломж сонголтыг нэмэгдүүлэх цорын ганц арга зам нь эдийн засгийн өсөлт юм.¹

Эрүүл мэнд, боловсрол зэрэг шалгуур үзүүлэлтүүдээс гадна амьдрал, хувь заяагаа шийдэхдээ мэдлэг авьяасаа бүрэн дайчлах эрх чөлөө сонголт хэмээх өөр нэг ойлголт хүний хөгжлийн үзэл баримтлалд нэмэгдэн орсон. Энэ нь хөгжлийн тухай тодорхойлолтыг баяжуулж хүний хөгжлийн тайланд тусгагдах болсон. Одоогийн байдлаар хүний хөгжлийн дэлхийн тайлан гарсаар 20 жил болж байгаа бөгөөд улс үндэстнүүд, бүс нутгийн түвшинд 600 гаруй тайлан гараад байна. НҮБ-ын Дэлхийн сайн дурын үйл ажиллагааны төлөв байдлын тухай энэхүү анхны тайланд хүмүүс амьдралдаа сайн дурын үйл ажиллагааг хэрхэн ашиглаж энэ нь тэдний хувийн амьдрал болоод эргэн тойрныхны бусад хүмүүсийн амьдралд ямар нөлөө үзүүлдэг болохыг голлон анхаарах зорилго тавьсан юм.

ХҮСНЭГТ 1. Сайн дурын үйл ажиллагаа бол хөгжлийн төлөвлөлтийн үнэ цэнэтэй бүрэлдэхүүн хэсэг юм.

Аливаа улс үндэстний хөгжлийн хөтөлбөрийн салшгүй үнэт бүрэлдэхүүн хэсэг нь сайн дурын ажиллагаа байх ёстой бөгөөд түүгээр хөгжлийн хөтөлбөрөө мөн хөгжлийн хамтын ажиллагааны бодлогоо баяжуулах нь зүйтэй. Хөгжил дэвшлийн аливаа хүчин чармайлтыг дэмжих шинэ арга замыг нээхэд сайн дурын үйл ажиллагааны арвин баялаг, туршлага, харилцан туслалцааны туршлагыг нэвтрүүлэх нь зүйтэй. Иргэдийн дунд энэхүү үйл ажиллагааны талаар тодорхой ойлголт бий болгож хөгжлийн туслалцаа үзүүлж байгаа орны сайн дурын байгууллага нь хөгжлийн туслалцаа авч байгаа орны сайн дурын байгууллагатай хамтран ажилласнаар хөгжлийн төлөө хамтын ажиллагаанд зохих дэмжлэгийг үзүүлэх боломжтой.⁴

Эх сурвалж: UNGA (2002 b) – НҮБ-ын Ерөнхий ассемблей

Сайн дурын үйл ажиллагаа нь хүмүүсийн хичээл зүтгэлийн нэг хэлбэр бөгөөд харамсалтай нь түүний ач холбогдлыг бүрэн гүйцэд ойлгодоггүй, хөгжлийн янз бүрийн хэлэлцүүлгэд тусгадаггүй. Тухайлбал: Мянганы хөгжлийн зорилтын хүрээнд сайн дурын үйл

ажиллагааны талаар тусгагдаагүй байна. Сайн дурын үйл ажиллагааны олон улсын жилийг тэмдэглэснээс хойш зарим нэгэн ахиц дэвшил, ялангуяа хөгжиж буй орнуудад тухайн жилийн хүрээнд дэвшүүлэн тавьсан 4 үндсэн асуудалтай холбоотойгоор, сайн дурын үйл ажиллагааг олон нийтэд таниулах, идэвхжүүлэх, мэдээлэл харилцааны үйл ажиллагааг дэмжих чиглэлээр тодорхой ахиц гарч байгааг үгүйсгээгүй юм.

Сайн дурын үйл ажиллагааг дэмжих зорилгоор улс орнуудын засгийн газрууд олон тооны зөвлөмжүүд боловсруулан гаргасан. Эдгээрийг НҮБ-ын Ерөнхий ассамблейн чуулганаар 2001 онд баталсан 56/38 тогтоолд тусгасан байдаг. Мөн НҮБ-ын бусад тогтоолд хавсралтаар тусгасан болно.² НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын олон тооны тайлан илтгэлд эдгээр зөвлөмжийг онцлон тэмдэглэсэн байдаг.³

Олон улсын сайн дурын үйл ажиллагааны жилийг тэмдэглэн өнгөрөөснөөс хойш 10 жилийн дараа гарч байгаагаараа цаг хугацааны хувьд энэхүү тайлан нь чухал ач холбогдолтой. Мөн дэлхийн улс орнууд одоо болон ирээдүй хойч үедээ нийгмийн ямар хэлбэрийг сонгон хөгжих нь зүйтэй вэ гэдэг талаар эрчимтэй хэлэлцүүлэг өрнөж байгаа энэ цаг үед гарч байгаагаараа онцлог юм.

Даяаршил дэлхийн улс орнуудын нийгэм, соёлын хэм хэмжээг хурдтайгаар өөрчилж зарим талаар үр өгөөж авчирч байгаа боловч зарим талаар сөрөг үр дагаварууд ч гарч байна. Өнөөдөр олон хүмүүс аж амьдралдаа тавих хяналтаа алдаж байгаа мэт сэтгэгдэл төрөх болсон. Сайн дурын үйл ажиллагаа нь амьдарч байгаа нийгмийнхээ өдөр тутмын амьдралд идэвхитэй оролцох боломжийг хүмүүст олгодог. Үүний ачаар хүмүүс нийгмийн амьдралд идэвхитэй оролцож өөрийн гэсэн байр суурьтай болж амьдралынхаа цаашдын хувь заяанд нөлөө үзүүлж чадах боломжтой боллоо гэсэн сэтгэгдэл тэдэнд төрөх юм.

ХҮСНЭГТ 2. Сайн дурын үйл ажиллагаа бол дэлхийн өөрчлөлт шинэчлэлтийн “хөлөг онгоцны аврах зангуу” нь юм.

“Даяаршилтай нүүр тулгарахад хүмүүст эцэс төгсгөлгүй далайн давалгаанд хаяагдсан ямар ч зангуу залуургүй сүйрсэн хөлөг онгоцон дээр байгаа мэт сэтгэгдэл төрдөг. Тэгвэл сайн дурын үйл ажиллагаа нь эдгээр хүмүүсийн хувьд зангуу нь болж өөрчлөлт шинэчлэлт хийхэд нь дэмжлэг үзүүлдэг.”

Эх сурвалж: Мария Харкин, “Европын парламентын гишүүн, НҮБ-ын Сайн дурын байгууллагын дээд зөвлөлийн гишүүн,” 2011.⁶

Түүхийн ямар ч цаг хугацаанд хүмүүс нийгмийн амьдралд идэвхитэй оролцож хөгжил дэвшлийн чиг хандлагад нөлөөлөхөөс илүү гайхамшигтай зүйл гэж байгаагүй. Дижитал харилцаа

холбооны хурдтай хөгжлийн тусламжтайгаар 1980-аад онд Латин Америк, 1990-ээд онд Зүүн Европ, саяхан Арабад ардчилсан үйл явцад оролцох хүсэл эрмэлзэлтэй байдгаа нотлон харуулсан. Ингэхдээ сайн дурын үндсэн бүх нийтийг хамарсан үйл ажиллагаанд идэвхитэй оролцсон.

Сайн дурын үйл ажиллагааг улс орон үндэстэн, бүс нутаг, дэлхийн хэмжээнд хөгжлийн асуудлын үндсэн бүрэлдэхүүн хэсэг болгон авч үзэх хэрэгтэй. Сүүлийн жилүүдэд сайн дурын үйл ажиллагааны олон төрөл хэлбэрүүдийг ихээхэн сонирхох болсон. Үүнийг судалгаа шинжилгээний ажлын сэдэв, янз бүрийн хурал чуулганы хэлэлцүүлгийн гол сэдэв нь сайн дурын үйл ажиллагаа болж байгаагаас мөн байгалийн гамшиг, олимпийн тоглолт дэлхийн хөл бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээн зэрэг спортын томоохон арга хэмжээний үеэр сайн дурынхны оролцооны талаар хэвлэл мэдээллээр өргөн сурталчилж байгаа зэргээс харж болно. Мөн иргэний идэвхи оролцооны нэг хэлбэр болох сайн дурын үйл ажиллагааг улс орнуудын засгийн газруудаас зөвхөн нийгэмд үйлчилж байгаа хүрээг нь өргөжүүлэх зорилгоор бус харин энэ байгууллагын үйл ажиллагааны эрхэмлэх зүйлийг дэмжих хандлага улам бүр нэмэгдэж байна.

2001 онд олон улсын сайн дурын үйл ажиллагааны жилийг тэмдэглэж байх үед тэр бүр түгээмэл биш байсан сонирхол одоо өсөн нэмэгдэж сайн дурын үйл ажиллагаатай холбоотой олон шинэ санал санаачлагууд гарч ирж байна.

Энэхүү тайланд сайн дурын үйл ажиллагааны талаарх судалгаа шинжилгээний зохиол эх сурвалжийг хуулбарлахыг хүссэнгүй. (Ашигласан эх сурвалж, материалыг үзэх). Харин сайн дурын үйл ажиллагааны талаарх үзэл бодлоо танилцуулж өнөө үеийн хөгжил дэвшил энх тайвны үндсэн зарчимтай ямар холбоотой болохыг тодруулах зорилго агуулж байна. Энд дурдагдсан иш татсан жишээг ихэвчлэн хөгжингүй орнуудаас авсан. Ингэснээр өнөө үед энэ асуудлаар хэвлэгдэн гарсан судалгаа шинжилгээний материалд тусгагдсан мэдээллийн тэнцвэргүй байдлыг залруулах боломжтой болох юм. Харин дэлхий дахинд сайн дурын үйл ажиллагааны төлөв байдлын тухай энэ тайлан нь дэлхий нийтэд зориулсан гэдгээрээ онцлог юм.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 56/38 дугаар тогтоолд сайн үйл ажиллагааг НҮБ болон түүний харьяа байгууллагууд улс орнуудын

засгийн газрууд хэрхэн удирдан чиглүүлэх нь зүйтэй вэ гэдэг талаар тодорхой зөвлөмжүүдийг тусгасан.⁷

Ингэхдээ дараах асуудлуудыг үндсэн чиглэл болгон авч үзсэн.

- Сайн дурын үйл ажиллагааг бодлогын загвар төлөвлөгөөнд тусгахгүй орхигдуулсанаар хүн ба нийгмийг холбож байдаг хамтын ажиллагааны уламжлал түүний гайхамшигтай үнэт ач холбогдлыг анхаарахгүй орхигдуулах эрсдэлтэй.⁸
- Дэлхий дахинд бүх улс оронд таардаг хамгийн сайн шилдэг загвар байдаггүй. Учир нь нэг улс орны хөгжилд нийцэж байгаа загвар нөгөө соёл уламжлалд тохиромжгүй байх нь түгээмэл үзэгдэл юм.
- Сайн дурын үйл ажиллагааг дэмжсэнээр засгийн газрын үйл ажиллагааг үгүйсгэх буюу эсвэл ажил эрхлэлтийг үгүй болгоно гэсэн үг биш юм.

САЙН ДУРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ӨНӨӨДӨР ДЭЛХИЙ ДАХИНД

Сайн дурын үйл ажиллагааны ёс зүй нь ямар ч нийгмийн байгуулалтын үед ямар ч хэлбэрээр оршин байдаг. 2001 оноос хойш идэвхитэй өргөн хүрээг хамран хийгдсэн судалгааны ажлын үр дүнд энэхүү үзэгдлийн талаар бидний ойлголт ихээхэн өөрчлөгдөж сайжирсан. Гэсэн хэдий ч барууны ертөнц болоод бусад улс оронд энэхүү үйл ажиллагааны мөн чанар хувь нэмрийн талаар буруу ойлголт түгээмэл хэвээр байна. Сайн дурын үйл ажиллагааны цар хүрээг тогтоох тусгайлсан, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн арга зүй байдаггүй. Гэхдээ ихэнхи судалгаанд сайн дурын үйл ажиллагааг түгээмэл, нийтлэг, өргөн тархацтай мөн нөлөөтэй талаар өгүүлсэн байдаг.

САЙН ДУРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШИНЭ ДҮР ТӨРХ

Сайн дурын үйл ажиллагаанд оролцох боломж сүүлийн үед даяаршил шинэ технологид нэвтрэх хувийн салбарын байгууллага аж ахуйн нэгжүүд нийгмийн хариуцлага биелүүлэхтэй холбоотойгоор санал санаачлагын үр дүнд улам бүр нэмэгдэх боллоо. Түүнээс гадна харилцаа холбооны шинэ төрөл болох үүрэн телефоны шинэ технологи сүлжээгээр дамжуулан сайн дурын үйл ажиллагаанд

оролцох боломж нээгдсэн нь өнөөдөр дэлхий дахинд олон хүмүүс энэхүү үйл ажиллагаанд оролцох үүдийг нээлээ.

Мэдээлэл авах, харилцан солилцох чухал үүрэгтэй “бичил сайн дурын үйл ажиллагааны нэгхэлбэр болох мессеж харилцааны нэгхэлбэр түгээмэл ашиглагдах боллоо. Энэ хэлбэрийг ямар нэг асуудлаар иргэдэд мэдээлэл хүргэх эсвэл санал асуулга авах үйлчилгээний чанарт хяналт тавих зэргээр ашиглаж байна. Онлайн буюу интернэтээр дамжуулах сайн дурын ажилд оролцох болсоноор цаг хугацаа орон зайд баригдахгүй үйл ажиллагаагаа явуулах боломж уян хатан байдлыг нэмэгдүүлсэн. Twitter, Facebook, Orkut зэрэг олон нийтийн харилцааны мэдээлэл солилцох сүлжээний тусламжтайгаар хүмүүс байгаль орчин ардчилал шинэчлэлийн асуудлаас эхлээд хамгийн сүүлд Арабын ертөнцөд гарсан нөхцөл байдалд холбоотой олон асуудлаар санал бодлоо солилцох болсон.

НҮБ-ын сайн дурын үйл ажиллагааны онлайн үйлчилгээний хөтөлбөрөөр дамжин сайн дураараа ямар нэгэн үйл ажиллагаанд оролцохыг сонирхож байгаа хүмүүсийг сайн дурын туслалцаа шаардлагатай байгаа байгууллагад холбоход Интернэт чухал үүрэг гүйцэтгэж байна. Сайн дурын үйл ажиллагааны онлайн гишүүнээр элссэнээр нийгэм олон нийтийн үйл хэрэгт идэвхитэй оролцох боломжийг бүрдүүлнэ.

Хэдийгээр олон улсын сайн дурын үйл ажиллагаа нь цоо шинэ үзэгдэл биш боловч даяаршлын эрин үед шинэ хэлбэр хэмжигдэхүүнээр дүр төрхөө өөрчилсөн. “Volantourism” буюу оюутны сайн дурын үйл ажиллагаа нь ихэнхдээ богино хугацаатай хэрэгждэг бөгөөд шинэ тутамд гарч ирж байгаа энэ хэлбэрийн нөлөөний талаар хэлэлцүүлэг нээлттэй өрнөж байна. Компани, байгууллага, ТББ, их дээд сургууль, шашны байгууллагууд, олон улсын сайн дурын үйл ажиллагаанд идэвхитэй дэмжлэг үзүүлж байна. Түүгээр ч барахгүй цагаачлагч иргэдийн дунд өөрийн эх орондоо зарим нэг эрдэм мэдлэг түгээхэд богино хугацаатай янз бүрийн арга хэмжээнд сайн дураар оролцох явдал нэмэгдэж байна.

Өөр нэг харьцангуй шинэ үзэгдэл бол хувийн салбарын оролцоо юм. Өнөөдөр томоохон гурван компанийн нэг нь албан хаагчдаа тулгуурлан ямар нэгэн төрлийн сайн дурын үйл ажиллагаа явуулах болсон. Мөн хувийн салбарын байгууллагууд орон нутгийн төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах явдал нэмэгдэж байна.

Барууны ертөнц болоод бусад улс оронд энэхүү сайн дурын үйл ажиллагааны мөн чанар хувь нэмрийн талаар буруу ойлголт түгээмэл хэвээр байна.

САЙН ДУРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА БА ХӨГЖЛИЙН ПАРАДИГМ

Сайн дурын үйл ажиллагаа ба тогтвортой амьжиргаа ба үнэт зүйлст тулгуурласан нийгмийн сайн сайхны хүрээнд сайн дурын үйл ажиллагааны хөгжилд оруулах хувь нэмэр нь онцгой ач холбогдолтой байна. Нийтийн түгээмэл ойлголтоос ялгаатай нь ядуу буурай бага орлоготой хүмүүс орлого сайтай чинээлэг хүмүүсээс илүү сайн дурын үйл ажиллагаанд оролцож идэвхи санаачлага гаргах нь илүү байдаг. Ийнхүү сайн дурын үйл ажиллагаанд хамрагдсанаар өөрийн болон гэр бүл, нийгэм хамт олны сайн сайханд мэдлэг ур чадвар нийгмийн харилцаагаа зориулах ёстой гэдгээ тэд ойлгож ухамсарлаж байдаг.

Нийгмийн хамгийн эмзэг давхаргын иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд тэднийг эдийн засаг, оюун санаа, нийгмийн хувьд нөхцөл байдлаас сайжруулахад нь сайн дурын үйл ажиллагаа онцгой чухал үүрэгтэй. Түүнээс гадна ядуурал ялгаварлан гадуурхалт, нийгмийн харилцааны тэгш бус байдлаас үүдэлтэй тэнцвэргүй байдлыг бууруулахад сайн дурын үйл ажиллагаа дэмжлэг болдог. Эмэгтэйчүүд, хүүхдүүд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, цагаачид, ХДХВ-ийн халдвартай хүмүүс ихэнхдээ ялгаварлан гадуурхагдаж байдаг.

Хүмүүсийн нийгмийн идэвхийг дэмжих нэг арга зам нь сайн дурын үйл ажиллагаа юм. Сайн дурын үйл ажиллагаа нь янз бүрийн хүчирхийлэл зөрчлийн хор хохиролыг бууруулах, арилгах замаар иргэдийн эрхэмлэх зүйлс нийгмийн хөгжлийн тэнцвэрийг хангахад, тэр ч бүү хэл зөрчил хямралын дараах сэргээн босгох үйл ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг олон жишээгээр баталж болно. Итгэлцлийг бэхжүүлэхэд нөлөөлдөг учраас сайн дурын үйл ажиллагаа нь хямралыг багасгаж зөрчилыг шийдвэрлэхэд тус дөхөм болдог байна.

Сайн дурын санал санаачлагын үндсэн дээр дайны дараах сэргээн босгох үйл ажиллагааны бүх нийтийн үйлсийн зорилгыг тодорхойлж болно. Орон нутгийн түвшинд иргэдийн идэвхитэй оролцоо, хамтын ажиллагаа нь хүмүүсийн нөхөрлөлийг бэхжүүлж маргаантай асуудлыг тайван замаар нааштай шийдвэрлэхэд сайн дурын үйл ажиллагаа чухал үүрэг гүйцэтгэдэг. Байгалийн гамшигтай холбоотойгоор сайн дурын үйл ажиллагаа хамгийн идэвхитэй явагддаг. Бусдын төлөө хүмүүнлэг тусламж дэмжлэг үзүүлэх хүн төрөлхтөний хамгийн энэрэнгүй үнэт зүйлийн

тод илрэл бол сайн дурын үйл ажиллагаа юм. Хэдийгээр хэвлэл мэдээллээр ихэнхдээ олон улсын сайн дурынхны үйл ажиллагаанд голлон анхаарсан мэдээлэл цацагддаг ч хүнд хэцүү үед хамгийн түрүүнд тухай газар оронд оршин суугаа хүмүүс, хөршүүд тусламжийн гараа сунгадаг. Энэ салбарын сайн дурын үйл ажиллагааны үүрэг урьд өмнө байгаагүйгээр улам нэмэгдэж байгаа нь байгаль цаг уурын өөрчлөлт, улам бүр хурдаа авч байгаа хотжилт болон бусад хүчин зүйлсийн улмаас гамшиг, аюултай үзэгдлүүд олон гарах болсон.

Нийгэм, олон нийтийн үүсгэл санаачлага дээр тулгуурлан анхан шатны сайн дурын үйл ажиллагаагаар дамжуулан байгалийн гамшигийн үед улс орнууд бэлтгэлтэй байх шаардлагатай гэсэн ойлголт улам бүр нэмэгдэж байна. 2005 онд байгалийн гамшигийн хор нөлөөг бууруулах тухай дэлхийн бага хурлаас аливаа гамшигийн эрсдэлийн үед хохиролыг бууруулахын тулд орон нутаг байгууллагын хүрээнд өөртөө үйлчлэх зохих нөөц бололцоотой байх хэрэгтэй гэсэн тогтоол гаргасан. 2010 оны хүний хөгжлийн тайланд “хөгжлийн гол асуудалд хүний хөгжлийг тавих нь оюуны хөгжлөөс илүү чухал ач холбогдолтой юм” гэж цохон тэмдэглэсэн юм. “Энэ нь өөрчлөлт шинэчлэлтэнд иргэдийн идэвхитэй оролцоог хангасан өргөн хүрээтэй хөгжил дэвшилд хүрнэ гэсэн үг юм.”

Бүхий л нийгмийн үед хүмүүсийн чадавхийг төлөвшүүлэх хамгийн үр дүнтэй тохиромжтой арга нь сайн дурын үйл ажиллагаа юм. Мөн хүмүүсийн чадавхи боломжийг сайжруулах, нийгмийн болоод хувь хүмүүс цаашлаад улс орны хөгжлийг дэмжих хамгийн тохиромжтой арга зам болох юм. Олон улсын хөгжлийн зорилтууд жишээлбэл: Мянганы хөгжлийн зорилтыг хангахын тулд, Улс орнуудын засгийн газрууд, Олон улсын томоохон оролцогчдын хүчин чармайлтыг дэмжихэд хэдэн зуун сая энгийн иргэдийн сайн дурын санаачлага хүчин чармайлт зайлшгүй шаардлагатай. Арвин баян туршлагатай сайн дурын ажиллагааг дэлхий дахинд хөгжил дэвшлийн агуу их хүч болохынх нь хувьд хүлээн зөвшөөрөвч бид таниулахыг хүсэж байна. Сайн дурын үйл хэрэг зөвхөн өгөгдсөн даалгавраар хязгаарлагддаггүй гэдэгт бид чин сэтгэлээсээ итгэж байна. Үүний тусламжтайгаар бид итгэлцэл, нийгмийн харилцаа тэгш эрх тогтвортой хөгжлийг бий болгож нийтлэг зорилгынхоо төлөө хамтран ажиллахад тусалдаг. Нийтлэг зорилгын төлөө тэмцэж байгаа хүмүүсийг нэгтгэж байдаг нь сайн дурын үйлс хэрэг нь ямар ч нийгмийн үед тохиолддог түгээмэл үзэгдэл юм.

Энэхүү тайлангийн үндсэн сэдэв нь хүний хөгжлийн алс хэтийн зорилгод хүрэхэд сайн дурын үйл ажиллагааны салшгүй мөн чанар нь чухал үүрэгтэй тухай юм.

Сайн дурын үйл ажиллагааны энэхүү онцлог нь дэлхий дахинд олон тэрбум хүмүүсийн амьдралд туслах боломжийг олгодог. Дэлхийн сайн дурын үйл ажиллагааны энэхүү тайлан уг байгууллагын үйл ажиллагааны тайлбар төдийгүй сайн дурынхны хувь нэмэр, эерэг нөлөөлийг танилцуулж байгаа баримт юм. Ялангуяа ядуу буурай орлого багатай нийгмийн хамгаалалт халамжаас гадуур үлдэж байгаа олон мянган иргэдэд хүрч үйлчилдэг учраас энэ үйл ажиллагааны нөлөөлөл нь гүн гүнзгий байдаг.

Сайн дурын үйл ажиллагааны салбарт ажилладаг хүмүүс болон энэ чиглэлийн эрдэмтэн мэргэдээс гадна уг асуудлыг сонирхох хүмүүсийн хүрээ улам бүр өргөжин тэлнэ гэдэгт найдаж байна. Өргөн далайцтай боловч хувь нэмрийг нь тэр бүр үнэлдэггүй энэхүү үйл ажиллагааны талаар цаашдын бодлого боловсруулагчид энх тайван хөгжил нийгмийн сайн сайхны талаарх ирээдүйн бодлогын хэлэлцүүлэгэд үүнийг анхааралтай аваасай гэж хүсэж байгаа учраас энэ мэдээллийг хөрвүүлэн танилцуулж байна.

Энэхүү тайлангийн үндсэн сэдэв нь хүний хөгжлийн алс хэтийн зорилгод хүрэхэд сайн дурын үйл ажиллагааны салшгүй мөн чанар нь чухал үүрэгтэй тухай юм. Аливаа хөгжлийн загварт иргэдийн эв нэгдэл нийгмийн оролцоо, идэвхи, эрх чөлөө, сэтгэл ханамж хувь хүн болгон нийгмийн сайн сайхан байдал зэрэг хүчин зүйлүүд ордог. Хувь хүмүүсийн амьдралын сайн сайхан байдал нь бусдын сайн сайхны төлөө оруулж байгаа хувь нэмэртэй нь салшгүй холбоотой. НҮБ-ын үйл ажиллагааны уламжлалд эдгээр үнэт зүйлс байнга нэгдмэл явж ирсэн. Гэвч дэлхийн энх тайван хөгжлийн хөтөлбөр төлөвлөгөөнд сайн дурын үйл ажиллагааны ач холбогдлыг үгүйсгэсэн хэвээр байна.

Эдгээр эрхэмлэх үнэт зүйл нь НҮБ-ын үйл ажиллагааны салшгүй хэсэг байсаар ирсэн. Сайн дурын үйл ажиллагааны энх тайван, хөгжлийн бодлогод тусгахгүй хэвээр байсаар байна. Үүнийг өөрчлөх шаардлагатай.

Сайн дурын үйлс нь дэлхийн нийтийн хүчирхэг, байнга нөхөн сэргээгдэх нөөц, аливаа улс үндэстний нийгмийн үнэт зүйлийн чухал бүрэлдэхүүн хэсэг гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Дэлхий дахинд тулгараад байгаа олон асуудал бэрхшээлийг даван туулж шийдвэрлэхэд сайн дурын үйл ажиллагаа асар чухал үүрэгтэй. Сайн дурын үйл ажиллагааны хувь нэмрийг илүү тодорхой ойлгож, түүнийг энх тайван, хөгжлийн хөтөлбөрүүд болон бодлогын үндсэн бичиг баримтууд, стратеги

төлөвлөгөө, үйл ажиллагаандаа тусгаж дэмжиж ажиллахад энэхүү тайлан хувь нэмрээ оруулна гэдэгт итгэлтэй байна.

НЭМЭЛТ ТАЙЛБАР

- 1 Хүний хөгжлийн тайлангууд
- 2 НҮБ-ын Ерөнхий Ассамблей ИНҮБ ЕАI, 2002b; НҮБ ЕА, 2003; НҮБ ЕА, 2006; НҮБ ЕА, 2009
- 3 НҮБ ЕА, 2002a; НҮБ ЕА, 2005; НҮБ ЕА, 2008
- 4 НҮБ ЕА, 2002b, хуудас. 6; Хавсралт: Улс орнуудын Засгийн газрууд болон НҮБ түүний системийн байгууллагууд сайн дурын үйл ажиллагааг дэмжих арга хэмжээний талаарх зөвлөмжүүд. II. Засгийн газрын дэмжлэг, (g), зүйл (i).
- 5 НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр болон Үнэлгээний Алба, 2003
- 6 НҮБ-ын СДХ, 2011с, хуудас. 9
- 7 НҮБ ЕА, 2002b
- 8 НҮБ ЕА, 2002b, хуудас. 3; Хавсралт: Улс орнуудын Засгийн газрууд болон НҮБ түүний системийн байгууллагууд сайн дурын үйл ажиллагааг дэмжих арга хэмжээний талаарх зөвлөмжүүд.Ерөнхий ойлголт, зүйл 6.
- 9 НҮБ ЕА 2002b, хуудас. 3; Хавсралт: Улс орнуудын Засгийн газрууд болон НҮБ түүний системийн байгууллагууд сайн дурын үйл ажиллагааг дэмжих арга хэмжээний талаарх зөвлөмжүүд. I.Ерөнхий ойлголт, зүйл 3.
- 10 НҮБ ЕА, 2002b, хуудас. 3; Хавсралт: Улс орнуудын Засгийн газрууд болон НҮБ түүний системийн байгууллагууд сайн дурын үйл ажиллагааг дэмжих арга хэмжээний талаарх зөвлөмжүүд. I.Ерөнхий ойлголт, зүйл 4.
- 11 НҮБ ЕА, 2010b, хуудас. 9
- 12 Хүний Хөгжлийн Үндэсний Комисс, НҮБ-ын СДХ болон Пакистан дахь НҮБ, 2004

Ашигласан эх сурвалж, материал:

- Хүний Хөгжлийн Тайлан. (n.d.). Хүний Хөгжлийн Үзэл Баримтлал 2011 оны 8-р сарын 21-нд <http://hdr.undp.org/en/humandev/> авч дахин засварласан
- Хүний Хөгжлийн Үндэсний Комисс, НҮБ-ын Сайн Дурын Байгууллага (НҮБ-ын СДБ), ба Пакистан дахь НҮБ-ын Салбар (2004 оны 12-р сар). Сайн Дурын Үйл Ажиллагаа болон Мянганы Хөгжлийн Зорилт сэдэвт олон улсын бага хурал [Төгсгөлийн Тайлан], Исламабад, Пакистан, 2011 оны 7-р сарын 23-нд http://www.worldvolunteerweb.org/fileadmin/docs/old/pdf/2005/050822PAK_MDG.pdf –с авч дахин засварлав
- НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр) болон and Үнэлгээний Алба (ҮА). (2003). Сайн дурын үйл ажиллагаа ба хөгжил. Үнэлгээний албанд (дугаар.), Чухал мэдээлэл. Нью Йорк, НҮ: НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр болон Үнэлгээний Алба.
- НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр). (1990). Хүний Хөгжлийн Тайлан НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр .
- НҮБ-ын Ерөнхий Ассамблей (НҮБ ЕА). (2002a). Сайн Дурын Үйл Ажиллагааны Олон Улсын Жил :Үр дүн болон ирээдүйн зорилтууд (A/57/352) [Ерөнхий Нарийн Бичгийн Дарга 57-р чуулганд тавьсан илтгэл – Хэлэлцэх асуудал 98].
- НҮБ-ын Ерөнхий Ассамблей (НҮБ ЕА). (2002b). Сайн дурын үйл хэргийг дэмжих тухай зөвлөмжүүд (A/RES/56/38) [ЕА-н 56-р чуулганаас баталсан тогтоол – Хэлэлцэх асуудал 108].
- НҮБ-ын Ерөнхий Ассамблей (НҮБ ЕА). (2010). Тогтвортой Хөгжлийн асуудлаар НҮБ-ын бага хурлуудын сэдэв, зорилго (A/CONF.216/PC/7) [Тогтвортой Хөгжлийн асуудлаар НҮБ-ын Бага Хурал, Ерөнхий Нарийн Бичгийн Даргын дэргэдэх Бэлтгэл Хороо, – Хэлэлцэх заалтууд Зүйл 2].
- НҮБ-ын Ерөнхий Ассамблей (НҮБ ЕА). (2003). Олон Сайн Дурын Үйл Ажиллагааны Жилийн Тайлан (A/RES/57/106) [ЕА-н 57-р чуулганаас баталсан тогтоол – Хэлэлцэх асуудал 98].
- НҮБ-ын Ерөнхий Ассамблей (НҮБ ЕА). (2005). Олон Улсын Сайн Дурын Үйл Ажиллагааны Жилийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай тайлан (A/60/128) [60-р чуулган дээр Ерөнхий Нарийн Бичгийн Даргын Тавьсан Тайлан-Хэлэлцэх асуудал 64].
- НҮБ-ын Ерөнхий Ассамблей (НҮБ ЕА). (2006). Олон Сайн Дурын Үйл Ажиллагааны Жилийн Тайлан (A/RES/60/134) [ЕА-н 60-р чуулганаас баталсан тогтоол – Хэлэлцэх асуудал 62].
- НҮБ-ын Ерөнхий Ассамблей (НҮБ ЕА). (2008). Олон Сайн Дурын Үйл Ажиллагааны Жилийн Тайлан (A/63/184) [63-р чуулган дээр Ерөнхий Нарийн Бичгийн Даргын Тавьсан Тайлан-Хэлэлцэх асуудал 58(b)].
- НҮБ-ын Ерөнхий Ассамблей (НҮБ ЕА). Олон Сайн Дурын Үйл Ажиллагааны Жилийн Тайлан (2009). (A/RES/63/153) [ЕА-н 63-р чуулганаас баталсан тогтоол – Хэлэлцэх асуудал 55 (b)].
- НҮБ СДБ (UNV). (2011). ДСДТ Дээд Хэмжээний Зөвлөлдөх Хорооны Хуралдаан [Тайлангийн дүн, хэвлэгдээгүй хувь]. Бонн, Герман: НҮБ-ын Сайн Дурын Үйл Ажиллагаа,